

## **Сургуулийн тухай хуулийн 20-р зүйлийн дагуу хэлний дэмжлэг авах эрхтэй сурагчдын эцэг эхчүүдэд зориулсан мэдээлэл, үндсэн сургуулиас өөр сургуульд суралцах болно.**

Чех улсад суурь боловсрол шинээр эзэмшиж буй эсвэл Чех улсын сургуульд хамгийн ихээр 24 сарын туршид заавал эзэмших боловсролд хамрагдсан хүүхэд нь үндсэн боловсролд нэгтгэж орохын тулд үнэгүй бэлтгэл авах эрхтэй, энэ нь Чех хэлний сургалт болно, гадаад сурагчдын хэрэгцээ хангах зорилготой ( цаашид зөвхөн „хэлний бэлтгэл“) болно.

Орон нутгийн бүс бүрт мужийн удирдлагаас анхаарч дор хаяж нэг сургуулийг томилсон, энэ сургууль дээр хэлний сургалтыг биечлэн (хувийн байдлаар) эсвэл алсын зайн аргаар (алсаас) явуулах болно.

Бүс нутагт мужаас томилогдсон сургуулиудын жагсаалтыг дараах вэб сайтаас олж болно:

.....

(жагсаалтанд аль сургуулиуд нь алсын зайнаас хэлний сургалт явуулах тухай мэдээллийг оруулсан байна).

Хэлний бэлтгэлийн бүлэгт хамрагдахын тулд хууль ёсны төлөөлөгч нь сурагчийг энэ бүлэгт оруулах тухай өргөдлийг бөглөх ёстой.

Өргөдлийн маягтыг:

- сургуульд хүлээн авдаг: .....
- эсвэл дараах хаягаар олж болдог: .....

Өргөдлийн нэг хэсэгт нь сурагч нь хэлний сургалтанд биечлэн (хувийн байдлаар) эсвэл алсын зайн (алсаас) оролцох эсэх тухай мэдэгдэл юм.

Хэрэв сурагч нь томилогдсон сургууль дээр хэлний бэлтгэлд биечлэн оролцох бол хууль ёсны төлөөлөгч нь түүнийг тухайн сургуульд хүргэж өгөх үүрэгтэй.

Хэлний сургалтын хүрээ **100-аас 200 цаг хүртэл** байна. Сургуулийн захирал нь сурагч бүрийн хувьд дэмжлэгийн хэмжээг (Чех хэлээр хэдэн цаг суралцах тухай) тогтоох болно, тэгэхдээ (тухайн сургуулийн) хэлний бэлтгэлд хамрагдах сурагчийн мэдлэгийг анхан шатны шалгалтаар (тестээр) баталгаажуулах болно.

Томилогдсон сургуулийн захирал нь сурагчийг өргөдөл гаргаснаас хойш 30 хоногийн дотор хэлний бэлтгэлийн бүлэгт бүртгэнэ.

Хэлний бэлтгэл нь хичээл зааж байх үед явагддаг. Хэлний бэлтгэлтэй давхцаж байгаа хичээлээс сурагчийг автоматаар чөлөөлж хэлний бэлтгэлд явуулдаг.

Хэрэв сурагч нь хэлний сургалтанд алсын зайнаас (алсаас) оролцох бол үндсэн сургууль нь (тэнд сурагч заавал эзэмших боловсролд хамрагддаг) түүнд алсын зайн хэлний сургалтанд ба хяналтанд хамрагдахын тулд сургуулийн мэдээллийн технологийг ашиглах боломжийг олгох болно.

Сурагчийн заавал эзэмших боловсролтой үндсэн сургууль ба Чех хэл заах гэж томилогдсон сургууль нь бие биетэйгээ хамтран ажиллаж, сурагчийн тухай мэдээлэл, сурагчийн хэлний сургалтын явц ба үр дүнгийн тухай мэдээллийг бие биедээ хуваалцан өгдөг.

---

Хүүхдээ хэлний бэлтгэлд хамруулахын тулд Таны хүүхэд нь Чех хэлний мэдлэгээ анхан шатны шалгалтаар баталгаажуулсан байх ёстой, үүнийг дараагийн хаягтай сургууль дээр гардаг:

Өдөрт: .....

Дээрх сургууль дээр ..... (сурагчийн нэр овог) дээр заагдсан сургууль дээр очно уу.

Чех хэлний мэдлэгийг анхан шатны шалгалтаар баталгаажуулсны үндсэн дээр Таны хүүхэд нь Чех хэлний хэдэн цагийн сургалтанд оролцох тухай тодорхойлж, хэлний бэлтгэл хийх бүлгэмд бүртгэх болно.

Хэлний сургалтын хуваарь ба түүний хэрэгжилтийг хууль ёсны төлөөлөгч, үндсэн сургууль ба хэлний сургалт явуулахаар томилогдсон сургууль нь хоорондоо хэлэлцэн тохиролцоно.

Хэрэв асуулт байвал дараах хаягаар холбоо барьна уу.

.....  
(эрх бүхий хүний нэр, холбоо барих утас - имэйл, зөвлөгөө өгөх цаг)